

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2024 ОНЫ АНХДУГААР ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 07 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН  
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЕС ДЭХ УДААГИЙН СОНГУУЛИАР БАЙГУУЛАГДСАН  
УЛСЫН ИХ ХУРЛЫН АНХДУГААР ЧУУЛГАНЫ  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА

2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 - 18
1. Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал	4 - 18

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн  
анхдугаар чуулганы Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын  
хорооны 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 19 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: Б.Батцэцэг, А.Ганбаатар, Ц.Мөнхтуяа, Г.Хосбаяр.*

**Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамыг нэр дэвшүүлж байгааг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах, Д.Энхтүвшин нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны даргад нэр дэвшигч Ч.Ундрам хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Г.Дамдинням, У.Отгонбаяр, О.Амгаланбаатар, О.Саранчулуун, Д.Бум-Очир, Ж.Галбадрах нар үг хэлэв.

**Д.Рэгдэл:** Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 4  
Бүгд: 14  
71.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 39 минут үргэлжилж, 18 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 77.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 58 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Д.РЭГДЭЛ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
12 цаг 19 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Рэгдэл:** Боловсрол, соёл,  
шинжлэх ухаан, спортын байнгын  
хорооны эрхэм гишүүдийнхээ амар  
амгаланг айлтгая.

Манай Байнгын хороонд 18  
гишүүн байдгаас одоогийн байдлаар 12  
гишүүн ирсэн.

Ирц бүрдсэн тул 2024 оны 07  
дугаар сарын 09-ний өдрийн  
хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх  
цохив/

Ирц 12 хүн ирсэн байна гэсэн.  
Очирбатын Амгаланбаатар ирсэн байна,  
Отгоншарын Батнайрамдал ирсэн байна,  
Батмөнхийн Батцэцэг ирээгүй байна,

Дуламын Бум-Очир ирсэн байна,  
Шинэбаярын Бямбасүрэн ирсэн байна,  
Жанчивын Галбадрах ирсэн байна,  
Амгаланбаатарын Ганбаатар ирээгүй  
байна, Гонгорын Дамдинням ирээгүй  
байна, Бадрахын Найдалаа ирээгүй  
байна, Цэндсүрэнгийн Мөнхтуяа  
ирээгүй байна, Ухнаагийн Отгонбаяр  
ирсэн байна, Д.Рэгдэл би ирсэн байна,  
Отгоны Саранчулуун ирсэн байна,  
Мягмардашийн Сарнай ирсэн байна,  
Чинбатын Ундрам гишүүн ирсэн байна,  
Ганбатын Хосбаяр ирээгүй байна,  
Бадарчийн Хэрлэн ирсэн байна,  
Сүхбаатарын Эрдэнэбат ирсэн байна.

Ингээд ирцийг танилцууллаа.

Хэлэлцэх асуудал өнөөдөр  
ганцхан асуудал хэлэлцэх юм байна.

Байнгын хорооны даргад нэр  
дэвшүүлэх тухай асуудал.

Байнгын хорооны гишүүдийн  
зүгээс нэмж хэлэлцэх асуудал дээр  
санал байгаа юу? Санал байхгүй юм  
байна.

Хэлэлцэх асуудалдаа орно.

### Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал

Ингээд хэлэлцэх асуудалдаа  
орлоо. /алх цохив/

Байнгын хорооны даргад нэр  
дэвшүүлэх тухай асуудал.

Дэгийн тухай хуулийн 23.1-д  
Байнгын хорооны даргад Байнгын  
хорооны гишүүдийн дотроос олонхын  
саналаар нэр дэвшүүлнэ гэсэн байна.

Тэгэхээр Улсын Их Хурал дахь  
Монгол Ардын намын бүлгээс Байнгын  
хорооны даргад нэр дэвшүүлэх талаар  
танилцуулга хийнэ.

Л.Мөнхбаатар дарга танилцуулга  
хийх юм байна. Таныг урьж байна.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн амрыг эрье.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Та бүгдэд танилцуулъя.

Ер нь Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу Байнгын хорооны даргыг ажилласан байдал, туршлагыг нь үндэслэн Байнгын хорооны гишүүдийн дундаас сонгож томилдог ийм журамтай.

Энэ байдлыг нь үндэслээд Чинбатын Ундрамыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа юм.

Чинбатын Ундрамыг товч танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам нь 1982 онд төрсөн.

Англи, орос, япон хэлтэй.

Нийслэлийн 23 дугаар сургуульд суралцаж байгаад сурагч солилцооны хөтөлбөрөөр Америкийн Нэгдсэн Улсын Терри Санфордын /Terry Sanford High School/ ахлах сургуульд суралцаж 1999 онд бүрэн дунд боловсрол эзэмшсэн, 2004 онд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад олон улсын Америкийн их сургуульд Бизнесийн удирдлагын бакалавр, мөн сургуульд 2005 онд магистрын зэрэг тус тус хамгаалсан.

2010 онд Япон Улсын Нагоя их сургуулийн Эдийн засгийн сургуульд эдийн засгийн ухааны докторын зэрэг хамгаалсан.

2010-2013 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд ахлах багш, тэнхимийн эрхлэгч, дэд профессор.

2013 оноос Монгол Улсын Их Сургуулийн захиргаанд сургалтын албаны дарга.

2017-2018 онд Захиргаа, дотоод хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал.

2018-2020 онд Санхүү, төлөвлөлт хариуцсан дэд захирлаар тус тус ажилласан.

2020 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд Та бүгдийг Чинбатын Ундрамыг Байнгын хорооны даргад дэмжиж өгөхийг Та бүгдээс хүсье.

**Д.Рэгдэл:** Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар танд их баярлалаа.

Одоо Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар өөр саналтай гишүүд байвал саналаа хэлж болно. Байхгүй байна. /алх цохив/

Өөр саналтай гишүүд байхгүй тул Байнгын хорооны даргад бид нэрээ дэвшүүлж дууслаа. /алх цохив/

Одоо Байнгын хорооны даргад нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамаас асуух асуулттай гишүүн байна уу? Бүгд тодорхой байх шиг байна. Асуулт алга гэж үзлээ.

Ж.Галбадрах гишүүнд микрофоныг өгөөдхөөрэй.

**Ж.Галбадрах:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг айлтгая.

Ч.Ундрам гишүүний хувьд өмнө нь Байнгын хорооны дарга хийж байсан туршлага байгаа. Хийж байгаагүй юу.

23.4 гэдэг юугаар энэ өмнө нь сонгогдож байсан гишүүд одоо манай Байнгын хороонд хэдэн гишүүн байгаа юм. Тийм ээ.

Энэ дотроос Монгол Ардын намын зүгээс Ч.Ундрам гишүүнийг оруулж ирж байгаа юм байна.

Бусад нам, эвслээс энд нэр дэвшигдээгүй байна гэж ойлголоо.

Тэгээд гишүүнээс асуух юм нь та одоо боловсролын ерөнхий хуулийг бид өмнө нь Их Хурлаар баталсан байж байгаа.

Тэгээд боловсролын ерөнхий хуулийн анхны санааг гаргахад, анхны эхийг бичилцэхэд би Боловсролын яаманд ажлын хэсэгт орж ингэж бичиж явсан хүн байгаа.

Тэгээд хууль маань хэлэлцүүлэгдээд эцсийн байдлаар гарах үед бас анх санаа гаргаж, хуулийн төслүүдэд оруулж ирсэн ийм нэлээн цавчигдана гэдэг юм уу. Тийм ээ. Орхигдсон чухал чухал заалтууд байдаг.

Тэгээд батлагдаад гарсны дараа үүнийг өөрчлөх шаардлага байна гэж бодож байгаа.

Тэгэхээр Байнгын хорооны даргын хувьд энэ хуулийн нэмэлт сайжруулсан төслийг оруулах, ер нь тэр талаар бодож

байгаа зүйл бий юж гэдгийг асууя гэж бодлоо.

**Д.Рэгдэл:** Нэр дэвшигч Ч.Ундрам гишүүн хариулна.

**Ч.Ундрам:** Миний хувьд өнгөрсөн хугацаанд 4 жил Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороондоо гишүүнээр ажилласан. Дарга хийж байгаагүй.

Тэгээд мэдээж боловсролын багц хуулийн ажлын хэсгийн гишүүнээр ажиллаад бид өнгөрсөн 4 жил хамтдаа Галаа багштайгаа, Г.Дамдинням гишүүнтэйгээ ингээд хамтраад ажилласан байгаа.

Боловсролын багц хууль дээр бид анх удаа 34 жилийн дараа их хууль болгож ийм реформын шинж чанартай өөрчлөлтүүдийг хийсэн байгаа.

Энэ хууль маань дөнгөж хэрэгжээд нэг хичээлийн жил өнгөрсөн байна.

Хэрэгжилтийн явцад нэлээн анхны хуулийн философи, концепц бас яг бүрэн буухгүй байгаа асуудлыг яг газар дээр энэ сумдад, орон нутагт ажиллаж байгаа багш нар маань хэлдэг.

Тэгэхээр хамгийн гол бидний нэг номерын барьж ажиллах ёстой асуудал бол энэ хэрэгжилтийг анхны бид ярьж байсан энэ концепцын дагуу хэрэгжүүлэх ажил чухал байх гэж бодож байна.

Дээрээс нь бид энэ хуулийн дагуу хөтөлбөрөө сайжруулах ажил маш чухал байгаа. Энэ хүлээгдэж байгаа.

Тэгэхээр эдгээр хэрэгжилтийн тал руугаа нэлээн анхаарч ажиллана гэж бодож байна.

Улсын Их Хурлын гишүүний хувьд Галаа багш та өөрөө бас хууль санаачлаад, энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг өргөн барих асуудал нээлттэй.

Ингэсэн тохиолдолд бид Байнгын хороогоороо бүгдээрээ хэлэлцээд цаашаа явж болно.

Тэгээд нэгэнт Байнгын хороо ингээд байнгын ажиллагаандаа ороод ирэх юм бид бүгдээрээ сууж байгаад нэг бүлгийн гишүүдийн хувьд ялангуяа бас энэ хууль дээр ямар ямар сайжруулалтууд хийж болох вэ, яах вэ гэдгээ ярилцаад төлөвлөгөө гаргаад ажиллах нээлттэй.

**Д.Рэгдэл:** Ч.Ундрам гишүүнд баярлалаа.

Ж.Галбадрах гишүүн хариулт хангалттай. Баярлалаа.

Дараа нь санал, хүсэлтээ ирүүлсэн Д.Энхтүвшин гишүүн асуулт асуух юм байна.

Д.Энхтүвшин гишүүнд микрофоныг нь өгөөдхөөрэй.

**Д.Энхтүвшин:** Ч.Ундрам гишүүнээс хоёр асуулт байна.

Нэгдүгээрт нь, Засгийн газрын бүтцийн тухай хууль дээр шинжлэх ухааны хэсгийг Эдийн засгийн яамтай нийлүүлэхээр ийм бүтэц зурсан байгаа. Энэ талаар ямар бодолтой байгаа вэ?

Боловсрол, шинжлэх ухааны яам гэдэг байсныг Эдийн засгийн яаманд шилжүүлэхээр болсон байгаа. Энэ талаар таны бодлыг сонсьё гэж бодож байна.

Хоёрдугаарт нь, энэ аж ахуйн нэгжүүдийн хувьд яг ажлын байр, хүний нөөцтэй холбоотой асуудал дээр энэ “**хосмог сургалт**”-тай холбоотой тогтолцоо их чухал байгаа.

Энэ тал дээр юу таны хувьд ямар бодолтой ажиллах вэ гэж ийм хоёр асуулт байна.

**Д.Рэгдэл:** Баярлалаа. Ч.Ундрам гишүүн хариулья.

**Ч.Ундрам:** Ерөнхийдөө улс орнууд Засгийн газраа байгуулахдаа шинжлэх ухааны асуудлыг янз бүрийн хэсэгт хуваарилж хариуцуулсан байдаг юм билээ.

Одоо жишээлбэл Япон Улсад гэхэд Ерөнхий сайдын шууд удирдлага доор шинжлэх ухааны асуудал хариуцсан зөвлөл нь удирдаад явдаг.

Тэгээд шинжлэх ухааны үндсэн суурь нь мэдээж боловсрол.

Суурь нь боловсрол боловчиг цаашдаа аж үйлдвэр, тэгээд төрийн бодлого гээд бүхий л салбар луу шинжлэх ухаан нь салаалаад уялдаатай ажиллах ёстой байдаг.

Тэгэхээр Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын бодлого нь энэ шинжлэх ухаанаа илүү эдийн засаг руугаа ойртуулах, бизнес рүүгээ ойртуулах, төрийн бодлого руугаа ойртуулахын тулд Эдийн засаг, хөгжлийн яам руу оруулж Засгийн газрын бүтцийг зурсан байна гэж миний хувьд ойлгож байгаа.



Гэхдээ яг энэ Засгийн газрын бүтцийг ярих үед бид үүнийг асуух ёстой байх гэж бодож байгаа. Яагаад ийшийгээ оруулсан бэ гэдэг үг, учрыг нь.

Гэхдээ Байнгын хорооны хувьд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хэвээрээ учраас шинжлэх ухаантай холбоотой аливаа асуудлыг манай Байнгын хороо руу оруулж ирж хэлэлцэх юм. Бид нар.

Тэгэхээр Байнгын хорооны хувьд бид хариуцдаг хэвээрээ.

Энэ “**хосмог сургалт**”-ын хувьд мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн Мэргэжлийн боловсролын тухай хууль дээр яг энэ асуудал байдаг.

Тэгээд миний хувьд ялангуяа мэргэжлийн сургалт бол компаниудтайгаа илүү ойрхон байх ёстой учраас ер нь компаниудтайгаа, мэргэжлийн холбоодтойгоо сургуулиуд нь хамтраад хэрэгжүүлээд явах юм бол илүү зөв зүйтэй гэдэг ийм байр суурьтай байдаг.

Гэхдээ бид Байнгын хороон дээр аливаа асуудлыг олонхоороо шийдвэрлээд парламентын зарчмаараа явах учраас энэ бол миний хувь хүний байр суурь шүү гэж хэлмээр байна.

**Д.Рэгдэл:** Ч.Ундрам гишүүнд баярлалаа.

Хариулт хангалттай гэж үзлээ. Тийм ээ.

Г.Дамдинням гишүүн асуулт асууна гэсэн үү?

Асуулт асууж, хариулт өгч ингээд дууслаа.

Одоо Байнгын хорооныхоо дарга болох гэж байгаа хүнд хандаж үг хэлэх гишүүд байгаа юу?

Г.Дамдинням гишүүн. Г.Дамдинням гишүүний микрофоныг өгөөрэй.

Ингээд ороод ирдэг. Дараалчихдаг юм байна шүү дээ. С.Эрдэнэбат гишүүн үг хэлэх юм байна.

Тэгэхээр үг хэлэх хугацаа 4 минут.

**С.Эрдэнэбат:** Ч.Ундрам гишүүнд хэлэхэд сургуулийн өмнөх боловсролоосоо авхуулаад бид ерөнхий боловсрол, тэгээд их дээд сургууль, насан туршийн боловсрол гээд энд нэлээн системтэй бид хандах хэрэгтэй байгаа.

Тийм учраас Байнгын хороо илүү идэвхтэй. Ялангуяа цэцэрлэг, сургуулиас авхуулаад өнөөдрийн тэр сургалтын агуулга, хөтөлбөр, дээрээс нь энэ соёл, мөн хүүхдүүдийн спорт, хичээл сургалтын асуудлаар онцгой анхаарал хандуулах ийм шаардлага байгаа.

Тийм учраас надад тухайлбал манай боловсрол, шинжлэх ухаан, сургуулийн өмнөхийн үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудаас маш олон саналууд тавьдаг. Тэр болгон анзаардаггүй орхиод байдаг асуудлууд байдаг.

Тухайлбал, хүүхдийн хоолны илчлэг, үнэ, тарифын өртгийн асуудал, ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн агуулгын асуудал.

Боловсролын хууль дээр ярьж байгаад нэг орхичихсон асуудал байж байгаа.

Өнөөдөр 60 нас хүрчхээд, 55 нас хүрчхээд сургуулийн өмнөх боловсрол цэцэрлэгт багшлаад байж байх чадалтай ч багш байна, чадалгүй ч хүмүүс байж байгаа.

Тийм учраас энэ асуудлыг нь дахиж Хөдөлмөрийн яам болон аль яам руу хуваарилах чиглэл нь яах юм байна. Тэр асуудлыг тэтгэвэрт гарах асуудлыг нь ялангуяа сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулиудын багш нарын хувьд нэлээн хүлээлттэй асуудал байгаа.

Энэ тал дээр анхаарч ажиллах шаардлага байгаа гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаарт, түрүүн Д.Энхтүвшин захирал хэллээ. “Хосмог сургалт” тогтолцоо руу орохоор болсон.

Энэ тал дээр хүүхдүүд хөдөлмөр эрхлэх асуудал л давхар яригдаад эхэлж байгаа юм.

Манайхан одоо яаж байна вэ гэхээр шууд аваачаад аж ахуйн нэгжтэй тохирчихно, болно гэдэг асуудал ярьдаг. 14, 15, 16 настай хүүхдүүд дээр хөдөлмөр эрхлүүлэх асуудал байгаа юм.

Тийм учраас энэ тал дээр нь тэр хүүхдийн эрх талаас нь, мөн гуравласан гэрээ гэж байдаг. Эцэг эх, сургуулийн захиргаа, ажил олгогч.

Дээрээс нь нэг зүйл нь орж ирдэг нь тэр хөдөлмөр эрхлэх шинж чанартай дадлага хийж байгаа юм харагдаад байгаа учраас Үйлдвэрчний эвлэлээр эрхийг нь

хамгаалах хүмүүсийг нь оруулж ирдэг юм.

Тэр тал дээр их анхаарах шаардлага байна.

Тэгээд хамгийн сүүлд нь хэлэхэд бид боловсрол дээр харж байхад ирээдүйд маш их олон ажлын байрууд байхгүй болно.

Нөгөө **“насан туршийн боловсрол”** буюу бид урьдчилан сэргийлж энэ хүмүүсийг мэргэжил, ур чадвар олох асуудал дээр нь Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хүний хөгжлийн яамтайгаа хамтарч ажиллах дээр эрхлэх асуудлын хүрээнд зэргэлдээ Байнгын хороодтойгоо хамтарч ажиллах шаардлага байгаа.

Тэгээд тэр үед нь маш их идэвхтэй хамтраад ажиллаад явах асуудал, ийм чухал зүйлүүд байгаа шүү гэдгийг хэлье. Тэгээд амжилт хүсье гэдгийг хэлье.

**Д.Рэгдэл:** Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням үг хэлнэ. Г.Дамдинням гишүүний микрофон.

**Г.Дамдинням:** Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Тэгээд Улсын Их Хурлын ес дэх сонгуулиар бүрдсэн төрийн эрх барих дээд байгууллага өөрийнхөө дотоод бүтэц, зохион байгуулалтыг хийж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргаар өмнөх парламентад боловсролын хуульд маш идэвхтэй хамтарч ажиллаж, энэ салбарт гал тогоонд нь буцлагдаж чанагдаж байсан хамтран зүтгэгч Ч.Ундрэм гишүүн маань орж ирж байгаад маш талархалтай байна. Ч.Ундрэм гишүүндээ амжилт хүсье.

Салбарыг мэдэхгүй гэх биш. Би бас өөрөө энэ салбарын хуулиудыг бүгдийг нь ахалж ажиллаж байсан.

Ч.Ундрам гишүүн манай ажлын хэсгийн гишүүн байсан. Би өөрөө энэ Байнгын хорооны дарга байсан.

Манай Байнгын хорооны идэвхтэй гишүүдийн нэг. Сэтгэлтэй хүн байсан. Орж ирж байгаа учраас, туршлагатай парламентч орж ирж байгаад сэтгэл өндөр байна.

Сонгуулийн хугацаанд бид орон нутгийн болон хот, суурин газруудын боловсролын салбарынхан, эцэг эхчүүд, ард иргэд, суралцагсадтай уулзаад явлаа.

Боловсролын багц хуулийг бид батлаад гаргасан үндсэн санаа бол **“хот, хөдөөгийн боловсролын ялгааг арилгах”** нэгдүгээр асуудал.

Энэ дээр л хэдүүлээ идэвх чармайлт гаргаж ажиллана шүү. Ч.Ундрам гишүүн ээ.

Энэ залуу гишүүдийн идэвхийг оруулаад, шинэ гишүүдээ оруулаад, ажлын хэсэг яаралтай зохион байгуулаад.

Боловсролын хууль бол сая Д.Энхтүвшин гишүүний яриад байгаа, С.Эрдэнэбат гишүүний яриад байгаа энэ **“хосмог сургалт”**, бас энэ Үйлдвэрчний эвлэл өөрөө үүсгэл санаачилгын байгууллагуудыг оруулах зэрэг асуудлууд бүрэн орчихсон байгаа.

Хуулиудад бид хангалттай хийгээд өгчихсөн.

Гол нь хэрэглэх. Хуулиа сайн хэрэглэх хэрэгтэй байна. Бид нар.

Манай гишүүд энэ багц хуулиудаа сайн уншмаар байгаа юм. Цаад утга санааг нь хармаар байгаа юм.

Оролцогч энэ бүх талууддаа хуулийн хэрэглээг нь сайжруулах тал дээр Байнгын хороо их санаачилгатай ажиллах ёстой болчхоод байна.

Ингэж байж бид энэ хот, хөдөөгийн боловсролын ялгаа, бид нарт тулгамдаад байгаа боловсролын оролцогч талуудын сул талууд болон боломжит талуудыг харж ажиллана. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал бол энэ салбарт ажиллаж байгаа боловсон хүчнүүдийн нийгмийн баталгааг нэлээн сайжруулсан. Бид нар.

Одоо бид энэ салбарт ажиллаж байгаа хүмүүсийн цалинг тогтмол өсгөдөг энэ систем рүү оруулах талаас нь анхаарах ёстой болчхоод байгаа. Өмнөх хуулиар бид ерөөсөө хийж чадаагүй.

Тэгэхээр үүнийгээ хэдүүлээ зүтгүүлэх ёстой.

Гуравт нь, түрүүн хэлсэн. Энэ салбарыг, энэ Байнгын хороог удирдаж хоёр жил орчим явсан хүний хувьд хэлэхэд Боловсролын яам байх нь байна. Манайд. Соёл, спортын яам байх нь байна. Тэгээд шинжлэх ухааныг хариуцах яам нь орж ирэх юм байна.

Тэгэхээр салбараа төлөөлөөд энэ яамдыг төрийн эрх барих дээд байгууллага бодлогыг нь зангидаж байгаа Байнгын хорооны хувьд Байнгын хорооны дарга минь яамандаа хөтлөгдөж явдаг Байнгын хорооны дарга биш яамдаа шахдаг, сайд нарыг шүүсийг нь шахдаг,

ажлыг нь хийлгэдэг, баздаг, төрийн бодлогыг хэрэгжүүлдэг Байнгын хорооны дарга байгаарай гэж найздаа захъя.

Тэгээд бид хураасан туршлага байдаг бол хуваалцаад аяндаа, сураагүй биш хэдүүлээ тэгээд зүтгэцгээе.

Тэгээд Ч.Ундрам гишүүндээ амжилт хүсье.

Энэ салбарт орж ирж байгаа гишүүд маань хамтраад саяын энэ бодлогууд дээр ажиллацгаана биз ээ. Тэгээд амжилт хүсье.

**Д.Рэгдэл:** Г.Дамдинням гишүүнд баярлалаа. Одоо Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр үг хэлнэ.

**У.Отгонбаяр:** Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн мэндийг эрэн мэндчилж байна.

Юуны түрүүн нэр дэвшигч Ч.Ундрам гишүүндээ баярласан талархсанаа илэрхийлж байна.

Сайхан туршлагатай, энэ Байнгын хороонд өнгөрсөн 4 жил сайхан ажилласан, боловсролын салбарт ажиллаж байсан ийм хүн нэр дэвшиж Байнгын хорооны дарга болох гэж байгаад нэгдүгээрт баяртай байна.

Өнгөрсөн хугацаанд орон нутагт нэлээн ажилласан. Миний бие.

Боловсролын багц хууль орон нутагт болж байгаа юм байна. Болохгүй зүйл ч бас байна.

Тийм учраас энэ дээр дахиж сайхан ажлын хэсэг гаргадаг юм уу, хөдөө орон нутагт үнэхээрийн болохгүй юм нь юу байгаа юм. Түүн дээр нэг дүн

шинжилгээ хийж засаж залруулах юмаа маш богино хугацаанд бид бүхэн засаж залруулах ёстой.

Энэ дээр таныг нэлээн идэвх санаачилгатай ажиллах байх гэж бодож байгаа.

Дараагийн асуудал бид бүхэн 76-аас 128 руу шилжсэн. Үндсэндээ шинэ тогтолцоо руу орж байгаа ийм шинэ парламент.

Тийм учраас бид бүхэн боловсролын салбарт өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлаа үргэлжлүүлэх, шинэчлэх ийм нийгмийн шаардлага байгаа гэдгийг манай Байнгын хорооны гишүүд, дарга хүмүүс маань бүр тархиндаа кодолмоор байгаа юм.

Бид бүхэн сонгуулиа бүсчилсэн хэлбэрээр явуулсан.

Цаашдаа Монгол Улсын хөгжил дэвшил бүсчилсэн байдлаар явна. Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт бүх салбарыг ер нь дандаа бүсчилсэн байдалтай, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уяж байгаа.

Тийм учраас хөдөө орон нутагт хэрэгжих бүсчилсэн хөгжлийн бодлого цаашаа явахад нэлээн томоохон дэмжлэг үзүүлэх салбар энэ боловсролын салбар.

Тийм учраас бид бүхэн маш товчхондоо Бүсчилсэн хөгжлийн бодлого гэдэг хот хөдөөгийн хөгжлийн ялгааг л арилгах гэж байгаа. Бид бүхэн.

Тийм учраас хөдөө орон нутаг руу чиглэсэн энэ боловсролын бодлого дээр энэ байнгын шинээр байгуулагдаж байгаа Байнгын хорооны гишүүд нэлээн тийм

идэвх чармайлт гаргаж ажиллана гэдэгт би итгэлтэй байгаа.

Энэ боловсролын салбарыг тэр дундаа хөдөө орон нутагт нэг шинэчлэл хийх чиглэлд чин сэтгэлээсээ ажиллах ийм миний хувьд сэтгэлийн үзүүрт ийм бодол хадаатай байгаа.

Тийм учраас Ч.Ундрам гишүүн энэ Байнгын хороог удирдаж ажиллах хугацаанд.../минут дуусав/

**Д.Рэгдэл:** Цаг нэмэх аргагүй юм байна шүү. Сонслоо.

Одоо Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар үг хэлнэ.

**О.Амгаланбаатар:** Та бүгддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Хэдүүлээ нэлээн хариуцлагатай л цаг хугацааг өнгөрөөх ийм цаг дээр ирсэн байна гэж харж байна.

Монголын хувьд бүх л тулгамдсан асуудлын үндэс нь энэ соёл, боловсрол л болчихоод байна л даа. Шинжлэх ухаан гурав.

Тэгэхээр бид нарын хувьд яг би ч одоо энэ талын арай л бас нэг хөдөө орон нутгийн зовлонг нь мэддэг хүний хувьд хэлэхэд манай энэ соёл, боловсрол, шинжлэх ухааны энэ салбар маань гэхдээ социализмдаа гацчихсан юм байна лээ.

Өнөөдөр бид нарын сонгож авсан энэ нийгэмд 30 гаруй жил явлаа. Тэгээд энэ 30 гаруй жилийн хугацаанд хамгийн шинэчлэл ороогүй, яг социализмдаа гацчихсан, хамгийн хоцрогдсон салбар энэ гурав болчихжээ.

Тэгэхээр энэ нэгэнт хэдүүлээ энэ өөрчлөлтийг л хийж чадахгүй бол яагаад ч урагшаа явахгүй. Бид нарын сонгож авсан нийгэм маань хэн хичээж зүтгэсэн сайхан амьдардаг л нийгэм.

Гэтэл энэ салбар үнэхээрийн бүр хоцрогдох хоцрогдохдоо бүр ингээд бусад бүх салбараасаа хэдэн арав дахин хоцорчихсон. Энэ салбарт ямар ч салхи ороогүй.

Сая Г.Дамдинням хэлж байх шиг байна.

Нэг хууль ингээд ороод явж байна. Тэр нь ч гэсэн бас гүйцэд хийгдээгүй. Яг үнэндээ хэлэхэд энэ дээр эрс өөрчлөлт хийж энэ социализмаас нь салахгүйгээр энэ урагшаа явахгүй.

Өнөөдөр энэ Улаанбаатарын утаа, Улаанбаатарын түгжрэл, ажилгүйдэл, хот хөдөө гэж яриад байна. Үгүй тэгвэл хотын боловсролд ч сайн юм алга байна шүү дээ. Хотын боловсрол сайн гэж хэн хэлээд байгаа юм. Элсэлтийн шалгалтаар ч тэр, олон улсын шалгалтаар ч тэр адагт нь л байж байгаа шүү дээ.

Тэгэхээр бид нарын хувьд энэ хот, хөдөө гэдэг талаасаа биш энэ салбарын эрс өөрчлөлтийг л хийхгүйгээр энэ Монголын асуудлыг шийдэхгүй.

Тийм учраас миний хувьд энэ Байнгын хороонд орсон байгаа. Монголыг өөрчлөх. Магадгүй энэ 30 жилийн энэ социализмаас нь энэ салбарыг салгаж чадах юм бол бид нарын хувьд энэ бусад жижиг асуудлууд, утаа гэдэг жижиг асуудал, түгжрэл гэдэг жижиг асуудал, ажилгүйдэл гэдэг жижиг асуудал.

Тэгэхээр үнэхээрийн маш хариуцлагатай ийм Байнгын хороо байж Та бүхэн маань аль болохоор идэвхтэй байгаарай. Гаргасан санаачилгуудаа тэгээд нам эвсэл хамаагүй дэмжээд яваарай гэж та хэдээсээ хүсье.

Тэгээд бүгдэд нь амжилт хүсье.

Тэгээд маш хариуцлагатай. Бид нарын хувьд тэр хөдөө аж ахуй, тэр төрийн байгуулалт энэ тэрээс илүүтэй бүх юмыг иж бүрээр нь цогцоор нь харж ингэж явах ийм боломж бүрдэж байна гэж л ингэж хэлэх байна. Тэгээд бүгдэд нь амжилт хүсье.

**Д.Рэгдэл:** О.Амгаланбаатар гишүүнд баярлалаа. Одоо О.Саранчулуун гишүүн үг хэлнэ.

**О.Саранчулуун:** Ч.Ундрам гишүүнд амжилт хүсье.

Бүгдээрэнд нь өдрийн мэнд.

Би хоёр асуудлаар санал бодлоо хэлэх гэсэн юм.

Нэгдүгээрт нь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн нийгмийн бодлого, үйл ажиллагааны талаар.

Монгол Улс ер нь сүүлийн 20 гаруй жил хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн асуудал нь дандаа **эрүүл мэндийн загварт тулгуурласан** гэж явдаг. Та бүхэн мэдэх байх.

Тэгээд **эрүүл мэндийн загварт тулгуурлана** гэдэг нь юу гэсэн үг вэ гэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нэг тийм өвчтөн, эмнэлгийн өвчтөн шиг өвдөж байгаа юм шиг асуудал руу хандаад байдаг.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн улсын төсөв, үйл ажиллагаа нь дандаа хамгийн хүнд хэцүү эмзэг бүлэг болох эрүүл мэндийн нэн шаардлагатай бүлэг рүүгээ чиглэсэн төсөв нь илүү жинтэй харагддаг.

Миний хэлэхийг хүсэж байгаа байр суурь юу вэ гэхээр дэлхий даяар нийгмийн модель руу шилжиж байгаа. Нийгмийн чиглэл.

Тэгээд **нийгмийн чиглэл** гэдэгт нь юу орж байгаа вэ гэхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө зөвхөн халамж болон асрамжийн үйлчилгээ чухал байна.

Гэхдээ түүн дээр нэмээд боловсрол, спорт, соёлын үйл ажиллагаа, нийгмийн оролцоо чиглэл рүү нь хандсан ийм үйл ажиллагаагаа илүү дэмжиж өгөөч ээ гэдэг ийм шаардлага тавигдаж байгаа.

Тэгээд энэ оролцоо нь хангагдахгүй байгаа учраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд маш их бухимдал, асуудлууд байдаг.

Миний хэлэхийг хүсэж байгаа хоёр дахь зүйл бол Та бүхэн маань ахмад настан руу чиглэсэн үйл ажиллагаа хөтөлбөр дээр бас эргэж харж өгөөч ээ гэж бас хэлмээр байгаа.

Би ч гэсэн өөрийнхөө хувьд чадах зүйлээрээ оролцоод ингээд ажиллана.

Ахмадад чиглэсэн ажлууд дотор бас л яг адилхан ахмадын ажил гэхээр сувилал, эрүүл мэндийн чиглэл рүүгээ илүү яваад нөгөө нийгмийн оролцоо нь дахиад л соёл, спорт, шинжлэх ухаанаасаа хоцрогдоод байгаа байхгүй юу.



Тэгэхээр хөгжлийн бэрхшээл рүү чиглэсэн бол одоо тэр сургагч багш нарын хувьд жишээлбэл анги танхим дээр ажиллаж байгаа багш нарт нь аргачлал байхгүй байх гэх мэтчилэн практик асуудлууд байдаг бол ахмадуудад чиглэсэн насан туршийн сургалтын төвүүд дээр ахмадад чиглэсэн тэр боловсролын, соёлын, спортын үйл ажиллагаанд нь бас сайн хэрэгжиж байгаа туршлага, аргачлал аягүй дутагдалтай харагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр ахмадуудын дунд эргээд энэ нь ганцаардал, тэгээд стресс, маш олон нийгмийн асуудлыг бий болгоод энэ нь мөн эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж байгаа.

Тэгээд ахмадынхаа асуудал руу дахин тодруулахад нийт ахмад настнуудын 70 хувь нь дандаа эмэгтэй ахмад настнууд байгаа.

Тэгэхээр бид энэ дээр ингээд зөвхөн эрүүл мэнд хөгжлийн бэрхшээлтэй болно, эрүүл мэндийн хувьд доройтно гэдэг чинь зөвхөн эрүүл мэндийн үйлчилгээ авна гэсэн үг бас биш байгаа байхгүй юу. Давхар нийгэм, соёлын үйлчилгээнээсээ ерөөсөө орхигдуулмааргүй байгаа.

Тэгээд үүнийг нь ингээд одоо энэ яамд, Засгийн газрын бүтэц батлагдаад үйл ажиллагаа болгож хэрэгжүүлбэ гэхээр бүх яамдад дээр тавьж байгаа төсөв дотор тэр хөгжлийн бэрхшээл, дагалдаад хүртээмж, ахмадыг анхаарсан асуудлууд хэр байгаа юм бэ гэдэг дээр дуу хоолой болоход манай энд байгаа Байнгын хорооны гишүүд болон Байнгын хорооны дарга Та бас ингээд дэмжиж өгөөч ээ. Энэ дээр бусад гишүүдээ

анхаарч ажиллаач ээ гэж уриалмаар байна.

**Д.Рэгдэл:** О.Саранчулуун гишүүнд баярлалаа.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир үг хэлнэ.

**Д.Бум-Очир:** Сайн байцгаана уу? Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Боловсролын салбарт хамгийн их, ялангуяа ерөнхий боловсролын салбарт олон асуудал тулгамдаж байгаа.

Та бүхэн мэдэж байгаа байх. Хамгийн зовлонтой хэцүү байгаа нь миний ойлгож байгаагаар хүний нөөцийн асуудал гэж би боддог.

Та бүхэн бүгдээрээ хөдөө орон нутагт яваад үзсэн байх. Тийм багш байхгүй, ийм багш байхгүй, нийгмийн багш байхгүй, түүхийн багш орж байна, химийн багш байхгүй, биологийн багш орж байна, англи хэлний багш байхгүй орос хэлний багш орж байна гээд ингээд бүр зах замбараагүй байгаа. Нөхцөл байдал.

Газар зүйн багш мэдээлэл зүй ордог, мэдээлэл зүйн багш физик ордог. Ингээд л ерөөсөө.

Энэ бүхний ард нэгд хүний нөөцийн асуудал байгаа гэдгийг Та бүхэн ойлгож байгаа байх.

Үүнээс болоод ямар асуудал гарч ирж байна вэ гэхээр боловсролын чанар унадаг. Аргагүй шүү дээ. Тэр багш 4 жил англи хэл заахаар их сургуульд сурсан болохоос биш орос хэл заахаар сураагүй шүү дээ.

Тэгэхээр энэ хүний нөөцийн асуудлыг бид нэн даруй шат дараатайгаар шийдэхэд нэлээд анхаарах шаардлагатай байгаа юм.

Хэрхэн шийдэх талаар сая Г.Дамдинням гишүүн хэлж байна. Тогтмол багшийн цалинг нэмдэг байх.

Манай төгсөгчид багш болохоо больчихсон. Би өөрөө Монгол Улсын Их Сургуулийн багш.

Багш болох хүн олдхоо байсан. Одоо энэ эрчээрээ Монгол Улсын хүн ам өсөж байгаа энэ тохиолдолд бид улам багшийн дутагдалд орно.

Тэгвэл бид яаж багшийнхаа боловсон хүчний нөөцийг хангах вэ? Ганцхан л томоохон арга байгаа. Миний ойлгож байгаагаар. Цалинг нь л тогтмол нэмэх.

Миний санал юу вэ гэхээр би бас өмнө нь хэлж байсан. Л.Энх-Амгалан сайдад ч хэлж байсан.

Жил болгон улсын төсөвт учиргүй их дарамт учруулахгүйгээр 5 ч юм уу, 10 хувь ингээд жил болгон нэмбэл яадаг юм бэ. 10 жилийн туршид. Эсвэл болдог бол 10 юм уу, 20 хувь ч байж болно. Жил болгон.

Тэгээд Монголын багш нарын цалинг дунджаас дээгүүр юм уу, бүр дээгүүрт өндөрт оруулах тэр ажил руу орвол яасан юм бэ. Тэгж байж хүн би төгсөөд багш больё гэдэг ийм хүсэл эрмэлзэлтэй болох байх. Нэгдүгээр зүйл.

Дараагийн нэг зүйл юу вэ гэхээр багшийн ачаалал хэт их байна. Ялангуяа аймаг болоод нийслэлийн сургуулиудад

манай хоёр хүүхэд өнгөрсөн жил нэг нь нэгдүгээр ангид ороод, тэрний өмнө хоёр жилийн өмнө нэг нь бас нэгдүгээр ангид орсон. Хорооллын энэ юу билээ, “Эрдмийн Ундраа” билүү гээд нэг сургуульд аваачаад өгсөн.

52 хүүхэд 09 сарын 01-нд.

Энэ жил дүүг нь аваачаад өгсөн. 54 билүү хүүхэд сууж байгаа юм.

Тэгээд 09 сарын 01-нээс хойш жаахан анги хуваарилалтыг нь өөрчлөөд, одоо тэгээд 46 орчим хүүхэдтэй.

Тэгээд багш нь хэлж байгаа шүү дээ. Хичээл ороход нэг хүүхдэд нэг минут зарцуулаад тойроод юм уу явж амждаггүй. Зарим хүүхэд дээрээ очиж амжаагүй байхад хичээл завсарлалчихдаг.

Тэгэхээр бид ийм нөхцөлд байгаа. Энэ асуудлуудыг бид шийдмээр байна.

Аймаг дээр бас ялгаагүй. Би бас нэлээн олон сургуулиудаар судалгаа энэ тэр хийж үзсэн.

Тэгэхээр энэ юу байгаа вэ гэхээр багшийн ачаалал байгаа юм. Англид миний мэдэхээр 25 хүүхэдтэй ангид туслах багш өгдөг. Манайд 44 хүүхэдтэй ангид туслах багш өгөх гээд туслах багш нь олохгүй эцэг эхчүүд нь туслаад сууж байдаг.

Гэх мэтчилний асуудлууд бий.

Тэгэхээр бид цаашдаа боловсролын асуудлаа нэлээд их анхаарахгүй бол одоо бас хүнд байдалд орох байх.

Тэгэхээр ингээд жил болгон тогтмол нэмье.



Дараагийн нэг зүйл нь. Миний цаг дуусаж байх шиг байна. Боловсролын асуудлаа бид их яриад шинжлэх ухааны асуудал хоцрогддог шүү. Д.Рэгдэл гуай маш сайн мэдэж байгаа.

Дээд боловсролын асуудал сүүлийн үед бас сайн яригдаж чадахгүй байгаа. Их дээд сургуулиудын нэгтгэх, нэгтгэхгүй гээд.

Тэгэхээр энэ асуудлуудыг ч гэсэн бид шат дараатайгаар асуудлуудыг нь сонсмоор байна. Их баярлалаа.

Ч.Ундрам гишүүнд ажлын амжилт хүсье.

Одоо Боловсролын тухай багц хуулийг батлуулсан туршлагатай. Тэр хууль дээр болох, болохгүй байгаа зүйлсийг нь мэдэж байгаа. Цаашид улам сайжруулахад өөрөө гар биеэр оролцоод ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Баярлалаа.

**Д.Рэгдэл:** Д.Бум-Очир гишүүнд баярлалаа.

Ингээд үндсэндээ системээр нэрээ өгсөн Улсын Их Хурлын гишүүд саналаа хэлээд дуусаж байна.

Тэгээд нэрээ оруулахаасаа хоцорчихсон манай Ж.Галбадрах гишүүн бас үг хэлье гэж байна.

Цөмөөрөө үгийг нь сонсьё. Тийм ээ. Тэгвэл 2 хүн байгаа юм байна. Үг хэлүүлчихье.

**Ж.Галбадрах:** Би товчхон хэлье.

Ч.Ундрам гишүүнтэйгээ ингээд парламентын гадна олон хамтарч ажиллаж байсан.

Түрүүн хэлсэнчлэн хуулийн төсөл дээр ажилласан.

Одоо манай Байнгын хороо бол их хүчтэй хүмүүстэй орж ирсэн байна гэж харж байгаа. Салбар салбарын төлөөлөл байж байна. Энэ хүмүүсийгээ маш сайхан зангидаад бүгдийнх нь саналыг нь сонсоод нээлттэй яваарай гэдгийг хүсмээр байна.

Нөгөө талаас би бол багш, боловсролын салбарын төлөөлөл гэж орж ирсэн хүний хувьд маш их судалгаа байгаа надад.

Би өөрөө яг хөдөө орон нутгийн 58 сургууль, нийтдээ 60 сургууль дээр яг менежментийн төслийг 3 жил орчим хийгээд ирээд түүн дээрээс маш их зүйлийг яг бодит газар дээрээс нь хараад ирсэн. Танд танилцуулах маш их олон санал, төлөвлөгөөнүүд ингээд бодож орж ирсэн зүйлүүд байгаа.

Манай туршлагатай гишүүд маань тэрийг хууль, дүрэм журам, тушаал болгох тал дээр нь хэдүүлээ анхаараад явъя.

Та түрүүн хэлж байсан. Гүйцэтгэл дээр их анхааръя гэсэн.

Бид нарын алдаад байгаа юм бол ерөөсөө л гүйцэтгэл дээр байгаа.

Боловсролын яамыг нэлээн сайн шахдаг. Ерөнхий газар, тэгээд бусад хүрээлэн энэ тэр гэсэн хүмүүстэй их сайхан хамтарч ажиллах тийм нээлттэй Байнгын хороо байя.

Бид чинь дэгээрээ Байнгын хороон дээрээ л сайн ярьдаг тийм л болсон байна лээ.

Тэгэхээр энэ тал дээр таныг хүсэж байна.

Тэгээд бүсчилсэн хөгжил гэж манай намын мөрийн хөтөлбөртэй байж байна. Бүсчилсэн учраас технологийн коллеж буюу Коосен гэдгийг хөгжүүлэх талаар Эдийн засгийн хөгжлийн яам их анхаарч байгаа.

Энэ тал дээр би өөрөө Коосен байгуулж ажиллаж ирсэн хүний хувьд нэлээн сайн туршлага байгаа.

Тэгээд яалт ч үгүй багш нарын нэр хүндийг өсгөх, хамгийн шилдэг хүүхэд багш болдог.

Сургуулийн барилга хамгийн гоё сайхан барилга байдаг тал дээр хэдүүлээ их олон зүйлийг санаачилж, би өөрөө бас хэд хэдэн сургуулийн барилга барьчихсан. Хувьдаа ингээд бариад ирсэн хүний хувьд зөндөө туршлагауд байгаа.

Тэгээд төрийн сургуулиуд ийм байвал зохимжтой байна гэдэг юмыг харж байгаа.

Эцэст нь би хувийн сургуулиудын төлөөлөл учраас хувийн сургуулиудыг Үндсэн хуулийнхаа үзэл санааны хүрээнд дэмжиж, бусад хуулийнхаа хувьд ингээд хэдүүлээ дэмжээд ингээд боломжийг нь өгөөд, харилцан суралцаад явах шаардлага бидний өмнө байгаа гэж бодож байна.

Танд ажлын амжилт хүсье. Баярлалаа.

**Д.Рэгдэл:** Баярлалаа. Энэ чинь дэгээрээ нэмж хүн орж ирж үг хэлж болдоггүй юм байна.

Тэгэхээр нэмж хүн үг хэлэх боломжгүй юм байна.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Санал хураалтын томьёололыг хэлье.

Улсын Их Хурлын гишүүн Чинбат овогтой Ундрамыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая. Санал хураалт эхэллээ. /алх цохив/

Байнгын хорооны даргад Ч.Ундрам гишүүн 71.4 хувиар дэмжигдлээ.

Саналаа өгч хуралд оролцсон бүх гишүүдэд баярлалаа.

Санал хураалтын дүн танилцуулчихлаа.

Ингээд Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцээд дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулах ёстой.

Энэхүү санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулна.

Ингээд хуралдаан хэлэлцэх асуудал амжилттай дууссан тул Байнгын

хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.  
/алх цохив/

Баярлалаа. Та нарт.

Хуралдаан 39 минут үргэлжилж, 12 цаг 58 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**